



ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 06 сарын 20 өдөр

Дугаар А/33

Улаанбаатар хот

Ажил, үйлчилгээний жагсаалт батлах тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 10 дугаар хуралдааны тэмдэглэл, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 17 дугаар хуралдааны тэмдэглэл, Газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэлийг 2021-2015 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан хотын стандартын төслийг боловсруулах, батлуулах, батлагдсан хотын стандартыг мөрдүүлэх, иргэд, олон нийтэд сурталчилан таниулах хүрээнд зохион байгуулах худалдан авах ажил, үйлчилгээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.Дээрх үйл ажиллагаанд шаардагдах 217,000,000 (Хоёр зуун арван долоон сая) төгрөгийг ажил гүйцэтгэх гэрээ, акт, гэрээ дүгнэсэн тэмдэглэлд үндэслэн Бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний зардлаас гүйцэтгэлээр нь тооцож санхүүжүүлэхийг Ахлах нягтлан бодогч (Б.Түмэнжин)-д зөвшөөрсүгэй.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Э.Даваахатан)-д үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ТӨМӨРДУЛАМ